

**СҮХБААТАР АЙМГИЙН ХАЛЗАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ 08 ДУГААР САРЫН МЭДЭЭ**

НЭГ. ТӨРИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын жилийн гүйцэтгэлийн үнэлгээ хийх шалгалтын дагуу 2021 оны төсөв баталсан тогтоол шийдвэр Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас гарах бусад холбогдох баримт бичгийг хариуцсан мэргэжилтэнд хүргүүлсэн.

ИТХ-ын дотоод ажил болон архивийн хадгаламжийн нэг бүрийг хайрцаглан цэгцэлж хаяг дугаар тавин ажиллаж байна.

б/ Тамгын газар төрийн удирдлагын ажлын чиглэлээр: Сумын төвийн ойролцоох 4 км –т бог мал байлгахгүй байх тал дээр анхаарч Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг ажиллаж 4 км дотор буусан малчидтай уулзаж, нүүх шаардлага тавьж ажиллаж байна.

Малын хөлийн татварын тухайд нийт 420 өрхийн 94 сая орчим төгрөг төвлөрөх ёстойгоос 8 дугаар сарын 1 ний байдлаар 35 өрхийн 9 сая 1 зуу мянган төгрөг төвлөрүүлээд байна.

ХОЁР. САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Энэ сард аймгаас авах санхүүгийн дэмжлэгээр 40955,9 мянган төгрөг авч, төсөвт байгууллагуудад 45646,4 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон байна. Татварын орлогоор энэ сард 3553,8 мянган төгрөг төвлөрсөн байна. Хагас жилээр нь авч үзвэл:Аймгаас авах санхүүгийн дэмжлэгээр 222137,4 мянган төгрөг авч,төсөвт байгууллагуудад 293143,0 мянган төгрөг олгож, татварын орлого 27067,5 мянган төгрөг төвлөрсөн байна.

ГУРАВ. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН АЖЛЫН ХҮРЭЭНД:

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль шинэчлэгдэн батлагдсантай холбоотойгоор “Төрийн албаны тухай болон Архив, бичиг хэргийн хөтлөлтийн тухай хуулиудын хэрэгжилт” сэдэвт арга зүйн сургалтыг 2021.08.18-ны өдөр нийт төрийн албан хаагчдад зохион байгуулж ажиллалаа.

**ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
БОДЛОГЫН ХҮРЭЭНД:**

Ерөнхий боловсролын сургууль: Хичээлийн жилийн бэлтгэлийг ханган сургуулийн гадна хашааг будаж, дотуур байрын гал тогоонд засвар хийсэн. Сургуулийн гадна орчинд хүүхэд эрсдэлт өртөж, гэмтэж бэртэж болзошгүй нүх, ил гарсан утас зэргийг булж далдалсан. Мөн байгууллагын гадна орчмын зэрлэгийг зулгааж ажиллалаа.

Сумын засаг даргын өгсөн албан бичгийн дагуу сургуулийн орчинд тарьсан модыг туулай орохоос сэргийлж тор татсан.

БСШУЯ-наас зохион байгуулсан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтанд сургуулийн захирал, номын санч, 8-р ангийн багш хамрагдсан.

Сурлагын хоцрогдлыг нөхөх арилгах чиглэлээрх сургалтанд APLUS.MN сайтад 14 багш, 2 удирдах ажилтан хамрагдсан. 8-р сарын 24-27ны өдрүүдэд энэ чиглэлээр сургалтанд суухаар бэлтгэл ажлаа ханган ажиллаж байна.

8-р сарын 16-25ны өдрүүдэд 1-р ангийн сурагчдыг цахимаар бүртгэсэн. Өнөөдрийн байдлаар 1-р ангийн сурагчдын ирцийн бүртгэл 87%-тай байна.

Байгаль орчны чиглэлээр: Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас зохион байгуулсан “Хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөнд дасах зохицох чадамж болон эрсдлийн менежментийг боловсронгуй болгох нь” сэдэвт цахим сургалтад хамрагдав.

Шонхор шувууны отогийг нэгийг орон нутагт байрлуулан 2 шонхор шувууны гэрээ байгуулан ажиллаж байна.

Газар зохион байгуулалтын чиглэлээр: Газрын кадастарын мэдээллийн сангаас 4 иргэний кадастарын зураг хэвлэж ажилласан. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийх компани тус суманд 2 хоног ажиллав.

ХЯНАСАН: ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА:

М.БАТБЭХ

МЭДЭЭ НЭГТГЭСЭН: ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ
МЭРГЭЖИЛТЭН

ХАРИУЦСАН
Д.ДАЙРИЙМАА

